

**АЖЛЫН ДААЛГАВАР
ҮНДЭСНИЙ БОЛОН АЙМГИЙН ТҮВШНИЙ ДУНД ХУГАЦААНЫ
ХӨГЖЛИЙН ТӨЛӨВЛӨЛТ ХИЙХЭД ДЭМЖДЭГ ҮЗҮҮЛЖ, УУР АМЬСГАЛЫН
НӨЛӨӨНД СУУРИЛСАН ТААМАГЛАЛ, УРЬДЧИЛСАН ТААМАГЛАЛД
ҮНДЭСЛЭСЭН САНХҮҮЖИЛТИЙН АРГА АРГАЧЛАЛЫГ БОЛОВСРУУЛАХ
ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭ**

1. Ажлын даалгаврын зорилго

Зөвлөх үйлчилгээний зорилго нь уур амьсгалын нөлөөнд суурилсан таамаглал, урьдчилсан таамаглалд үндэслэсэн санхүүжилтийн арга аргачлал, удирдамж, арга хэрэгслийг боловсруулж, шинээр боловсруулсан арга аргачлал, удирдамж, арга хэрэгслийг ашиглан үндэсний болон орон нутгийн түвшний дунд хугацааны төлөвлөлт хийхэд Засгийн газарт дэмждэг үзүүлэхэд оршино.

2. Зөвлөх ажлын хүрээ

Гэрээний хугацаанд дараах даалгаврыг зөвлөх баг гүйцэтгэнэ. Үүнд:-

1. Уур амьсгалын нөлөөллийн нөхцөл байдал, тодорхой цаг хугацаанд уур амьсгалын өөрчлөлтийг тооцож буй одоогийн арга аргачлал, удирдамжийг судалж, үнэлэх (ялангуяа дунд болон богино хугацаанд авч хэрэгжүүлэх бодитой арга хэмжээ, урт хугацаанд тодорхойлсон зорилгыг онцлон судална)

- Одоогийн үндэсний болон аймгийн түвшинд уур амьсгалын өөрчлөлт, эрсдэл, эмзэг байдлыг хэрхэн үнэлж, дасан зохицох төлөвлөлтийг хэрхэн уялдуулан хийж байгаа гэдэгт үнэлэлт дүгнэлт өгөхөд шаардлагатай мэдээ мэдээллийг цуглуулах;
- Тухайн орон нутгийн онцлог болох эмзэг байдал, эрсдэлийн үнэлгээ (нөлөөлөл, эрсдэлийг тооцоолон гаргаж), амьжиргааны байдлыг харгалзан мэдээлэл цуглуулах, боловсруулах, урьдчилан таамаглах чадварыг сайжруулах чиглэлээр үнэлгээ хийх;
- Олон улсын зөвлөхийн хамт өмнө тохиолдсон хэд хэдэн цаг агаарын гамшигт үзэгдлүүдийг судалж, эрсдэл, эмзэг байдлыг үнэлэх механизмыг ойлгосны үндсэн дээр уур амьсгалын нөлөөнд суурилсан таамаглал, урьдчилсан таамаглалд үндэслэсэн санхүүжилтийн арга аргачлал, удирдамж, арга хэрэгслийг боловсруулах;
- Түншлэл, эрсдэлийн үеийн харилцаа холбоо, нөлөөллийн талаарх мэдээлэл, арга аргачлалын дүн шинжилгээ, гамшигт үзэгдлийн мэдээллийн талаарх тодорхой бүтцийг хэн, хэзээ, хаана, ямар нөлөөлөл үзүүлсэн гэх мэтээр нарийн тодорхойлох;
- Статистик мэдээ мэдээлэл, газар зүйн мэдээллийн системийг ашиглан уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөлөл, эмзэг байдлын мэдээллийн санг байгуулах.

2. Цуглуулсан мэдээнд үндэслэн олон улсын зөвлөхийн удирдамжийн хүрээнд арга аргачлал, удирдамж, арга хэрэгслийг шинээр боловсруулж, арга аргачлал, удирдамж, арга хэрэгслийг ашиглан үндэсний болон орон нутгийн түвшний дунд хугацааны төлөвлөлт хийхэд Засгийн газарт дэмждэг үзүүлэх:

- Уур амьсгалын нөлөөнд суурилсан таамаглал, урьдчилсан таамаглалд үндэслэсэн санхүүжилтийн арга аргачлал, удирдамж, арга хэрэгслийг

боловсруулж, уур амьсгалын өөрчлөлт, эрсдэл, эмзэг байдал, дасан зохицох арга хэмжээтэй уялдсан төлөвлөлтийг хэрхэн хийх талаар зөвлөмж гаргана.

- ДЦУБ-аас дэмжлэгтэй Нөлөөлөлд суурилсан урьдчилан таамаглах аргачлалыг (IBF) орон нутгийн нөхцөл байдалд тохируулах (үүнд усны нөөц, бэлчээрийн гарц/гэжээл, зудын нөхцөл байдалд үзүүлэх үйл ажиллагааны нөлөөллийн загварыг боловсруулах);
 - Уур амьсгалын өөрчлөлтийн урьдчилсан мэдээлэлд суурилсан санхүүжилтийн схемийг одоо байгаа санхүүгийн болон улсын төсвийн зохицуулалтын механизмтай уялдуулан оновчтой болгох арга замыг улс, аймгийн түвшинд санал болгоход дэмжлэг үзүүлнэ. ОУУЗХ-оос хөдөөгийн эмзэг малчдад чиглэн хэрэгжүүлсэн уур амьсгалын өөрчлөлтийн урьдчилсан мэдээлэлд суурилсан санхүүжилтийн жижиг төслийн сайн туршлагыг харж болно. Энэхүү төсөл нь зардал-үр ашгийн нэмэлт шинжилгээ бүхий зудын эсрэг таамаглалд суурилсан санхүүжилтийн (FBF) модулийг боловсруулсан.
 - Уур амьсгалын өөрчлөлтөөс үүдэлтэй эрсдэл, эмзэг байдалтай уялдуулан, дасан зохицох арга замыг урт хугацааны бодлого төлөвлөлтөд тусгах, холбогдох санхүүжилтийг тооцоход Эдийн засгийн хөгжлийн яам, байгаль орчин, аялал жуулчлалын яам, ХХААХҮЯ-нд дэмжлэг үзүүлэх;
 - Ногоон санхүүжилтийн бодлогын үндсэн үзэл баримтлалын хүрээнд уур амьсгалын нөлөөнд суурилсан таамаглал, урьдчилсан таамаглалд үндэслэсэн санхүүжилтийн загварыг улсын төсвийн төлөвлөлтийн схемд оруулах;
 - Төлөвлөлтийн чиглэлээр холбогдох бодлого, шийдвэр гаргагчидтай шаардлагатай уулзалтуудыг зохион байгуулж, уур амьсгалын өөрчлөлтийн тухай хууль тогтоомжийн төсөлд уур амьсгалын мэдээлэлд суурилсан шийдвэр гаргах зарчмыг тусгахад БОАЖЯ-нд шаардлагатай дэмжлэг үзүүлнэ.
 - Уур амьсгалын мэдээлэлд суурилсан төлөвлөлтийн механизмыг хэрэгжүүлэх үе шатны асуудлаар холбогдох талууд, Эдийн засаг, хөгжлийн яам, Сангийн яамтай зөвлөлдөх уулзалтыг хийх;
 - Уур амьсгалын нөлөөнд суурилсан таамаглал, урьдчилсан таамаглалд үндэслэсэн санхүүжилтийн арга аргачлал, удирдамж, арга хэрэгслийг боловсруулж, уур амьсгалын өөрчлөлт, эрсдэл, эмзэг байдал, дасан зохицох арга хэмжээтэй уялдсан төлөвлөлтийг хэрхэн хийх талаар зөвлөмжийг БОАЖЯ, ХХААХҮЯ-нд танилцуулна.
 - Гарсан зөвлөмж, саналыг БОАЖЯ, ХХААХҮЯ, НЗБХХ, төслийн нэгжтэй хэлэлцэж, тайландаа нэгтгэн оруулна.
- 3. Засгийн газрын холбогдох албан хаагчдад уур амьсгалын өөрчлөлтөд суурилсан төлөвлөлт хийх чиглэлээр сургалт хийх, нэгдсэн тайлан гаргах**
- БОАЖЯ болон төслийн нэгжид зөвлөгөө өгч, дэмжлэг үзүүлэх;
 - Уур амьсгалын нөлөөнд суурилсан таамаглал, анхааруулга өгөхтэй холбоотой ерөнхий ойлголт, хэрэглэгчдийг оролцуулах, үйлчилгээ үзүүлэх чиглэлээр сургалт хийх;
 - Сургалт хийхэд шаардлагатай тараах материал, гарын авлагыг боловсруулах, ялангуяа бэлэн байдлыг хангах, бодлогоор зохицуулах, хариу төлөвлөлт хийх, мониторинг хийх, сайжруулах чиглэлийн ажлууд, мэдээллийг түгээх, нөөцийг татан нэмэгдүүлэх чиглэлээр сургалт хийнэ.

- Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох, эрсдэл, эмзэг байдлыг даван туулах чиглэлээр хийж байгаа төслийг хэрэгжилтийн явцад зөвлөгөө, чиглэл өгөх
- Нэгдсэн тайланг олон улсын зөвлөлтэй хамт боловсруулж, БОАЖЯ, төслийн нэгжид хүлээлгэн өгөх

Хүлээгдэж буй үр дүн, үр нөлөө болон төлбөрийн хуваарь

Үр дүн	Хугацаа	Шаардлагатай хяналт, зөвшөөрөл	Төлбөр (%), хугацаа
Эхлэлийн тайлан Дараахаас бүрдэнэ: <ul style="list-style-type: none"> - Дэлгэрэнгүй ажлын төлөвлөгөө, хуваарийг гаргах - Хөдөө томилолтоор ажиллах хуваарь, логистик ажлыг төлөвлөх. Аймаг тус бүрд доод тал нь 2 удаа очиж ажиллана. 	Гэрээ зурснаас 20 өдрийн дотор	БОАЖЯ, ТХН болон НҮБХХ	Нийт төлбөрийн 10%
Үр дүн 1: Явцын тайлан. Уур амьсгалын нөлөөллийн нөхцөл байдал, тодорхой цаг хугацаанд уур амьсгалын өөрчлөлтийг тооцож буй одоогийн арга аргачлал, удирдамжийг судалж, үнэлэх <ul style="list-style-type: none"> - Үндэсний болон аймгийн түшинд уур амьсгалын өөрчлөлт, эрсдэл, эмзэг байдлыг хэрхэн үнэлж, дасан зохицох богино, дунд, урт хугацааны төлөвлөлтийг хийж байгаа одоогийн арга аргачлалыг судалсан тайлан. - Тухайн орон нутгийн онцлог болох эмзэг байдал, эрсдэлийн үнэлгээ (нөлөөлөл, эрсдэлийг тооцоолон гаргаж), амьжиргааны байдлыг харгалзан мэдээлэл цуглуулах, боловсруулах, урьдчилан таамаглах чадварыг сайжруулах чиглэлээр хийсэн үнэлгээ. Аймаг бүрд дор хаяж нэг удаа газар дээр нь очиж мэдээлэл цуглуулах. - Статистик мэдээ мэдээлэл, газар зүйн мэдээллийн системийг ашиглан нөлөөлөл, эмзэг байдлын мэдээллийн санг байгуулах - Одоогийн үндэсний болон аймгийн түшинд уур амьсгалын өөрчлөлт, эрсдэл, эмзэг байдлыг хэрхэн үнэлж, дасан зохицох төлөвлөлтийг хэрхэн уялдуулан хийж байгаа гэдэгт өгсөн үнэлгээ дүгнэлт 	Эхлэлийн тайлан ирүүлсний дараа 1 сарын хугацаанд	БОАЖЯ, ТХН болон НҮБХХ	Нийт төлбөрийн 30%
Явцын тайлан 2. Цуглуулсан мэдээнд үндэслэн олон улсын зөвлөхийн удирдамжийн хүрээнд арга аргачлал, удирдамж, арга хэрэгслийг шинээр боловсруулж, арга аргачлал, удирдамж, арга хэрэгслийг ашиглан үндэсний болон орон нутгийн түвшний дунд хугацааны төлөвлөлт хийхэд Засгийн газарт дэмждэг үзүүлэх: <ul style="list-style-type: none"> - Уур амьсгалын өөрчлөлт, эрсдэл, эмзэг байдал, дасан зохицох арга хэмжээг хэрхэн уялдаатай төлөвлөх асуудлыг зохицуулсан арга аргачлал, удирдамж, арга хэрэгсэл 	Анхны явцын тайлан ирүүлснээс 2-3 сарын дотор	ТХН, НҮБХХ болон бусад холбогдох талууд	Нийт төлбөрийн 30%

Үр дүн	Хугацаа	Шаардлагатай хяналт, зөвшөөрөл	Төлбөр (%), хугацаа
<ul style="list-style-type: none"> - Уур амьсгалын нөлөөнд суурилсан таамаглал, урьдчилсан таамаглалд үндэслэсэн санхүүжилтийн загварыг улсын төсвийн төлөвлөлтөд суулгах удирдамж - Уур амьсгалын нөлөөнд суурилсан таамаглал, урьдчилсан таамаглалд үндэслэсэн санхүүжилтийн арга аргачлал, удирдамж, арга хэрэгслийг боловсруулж, уур амьсгалын өөрчлөлт, эрсдэл, эмзэг байдал, дасан зохицох арга хэмжээтэй уялдсан төлөвлөлтийг хэрхэн хийх талаар гаргасан зөвлөмж - Уур амьсгалын өөрчлөлтийн мэдээлэлд суурилсан Урт хугацааны бордлого, төсвийн төлөвлөгөөг боловсруулахтай холбоотой талуудтай хийсэн зөвлөлдөх уулзалтын тайлан - ДЦУБ-аас дэмжлэгтэй Нөлөөлөлд суурилсан урьдчилан таамаглах аргачлалыг (IBF) орон нутгийн нөхцөл байдалд тохируулах (үүнд усны нөөц, бэлчээрийн гарц/тэжээл, зудын нөхцөл байдалд үзүүлэх үйл ажиллагааны нөлөөллийн загварыг боловсруулах) талаар хийсэн тайлан; - Уур амьсгалын өөрчлөлтийн урьдчилсан мэдээлэлд суурилсан санхүүжилтийн схемийг одоо байгаа санхүүгийн болон улсын төсвийн зохицуулалтын механизмтай уялдуулан оновчтой болгох арга зам, стратеги 			
<p>Үр дүн 3: Мэдээлэл түгээх болон сургалт:</p> <ul style="list-style-type: none"> - Ногоон санхүүжилтийн бодлогын үндсэн үзэл баримтлалын хүрээнд уур амьсгалын нөлөөнд суурилсан таамаглал, урьдчилсан таамаглалд үндэслэсэн санхүүжилтийн загварыг улсын төсвийн төлөвлөлтийн схемд оруулсан тайлан; - Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох, эрсдэл, эмзэг байдлыг даван туулах чиглэлээр хийж байгаа төслийг хэрэгжилтийн явцад өгсөн зөвлөгөө, чиглэл - Сургалт хийхэд шаардлагатай тараах материал, гарын авлага - Шинэ арга аргачлалтай холбоотой гаргасан мэдлэгийг түгээх 3 бүтээгдэхүүн (доод тал нь) - Зөвлөх үйлчилгээний хүрээнд хийж гүйцэтгэсэн ажлуудын биелэлт, зөвлөхийн ажлын явцад ТХН-д дэмжлэг үзүүлсэн талаарх тайлан, сурсан сургамжаас авсан зөвлөмжийг оруулсан эцсийн тайланг Монгол, Англи хэл дээр боловсруулж БОАЖЯ, ТХН-д хүргүүлнэ. 	Гэрээний хугацаа дуусахаас хоёр сарын дотор	НҮБХХ-ийн шинжээч болон ТХН -ийн хангалттай үр дүнд үндэслэн, БОАЖЯ, ХХААХҮЯ болон холбогдох талууд	Нийт төлбөрийн 30%

Ажлын даалгавар

Баталсан:

НҮБХХ-ийн Хөтөлбөрийн шинжээч Х.Хишигжаргал

